



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 5/99

Номгон

Хавдрын эрт илрүүлэг, осол гэмтлийн
тандалт, сэргийлэлт хариуцсан эмч
Г.Бямбацэцэгт ажил
хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх заалт, байгууллагын Хамтын гэрээний 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавдрын эрт илрүүлэг, осол гэмтлийн тандалт, сэргийлэлт хариуцсан эмч Ганболдын Бямбацэцэгт байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн шийдвэрээр 2022 оны 11 дүгээр сарын 22-ний өдрөөс эхлэн Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан эмчийн ажил үүргийг түр хавсран гүйцэтгүүлж, тухайн албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож нэмэгдэл хөлс олгосугай.

2. Бодлогын баримт бичгийг бүрэн гүйцэт хяналтандаа авч, түүний хэрэгжилт, холбогдох тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн, баталгаажуулж, хийгдсэн ажлын үр дүнг тайлагнан, хариуцлагатай ажиллахыг (Г.Бямбацэцэг)-д үүрэг болгосугай.

3. Хавсран гүйцэтгэсэн ажлын цалинг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ



642201418